

**Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал** (2015 оны 3 дугаар сарын байдлаар)

**I. Нийгмийн үзүүлэлт**




**I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.**

2015 оны 3-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 569 болж, 2014 оны мөн үеэс 501 хүнээр, өмнөх сарынхаас 98 хүнээр тус тус буурав.

Ажилгүйчүүдийн 47,45 хувь буюу 270 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 94 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 29 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 69,07 хувь буюу 18 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс тайлант хугацаанд 238 иргэн хасагдсан байна.

Зураг I.1

**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 3 дугаар сарын эцсийн байдлаар**




Тайлант сард бүртгүүлсэн 140 ажилгүй иргэний 25,71 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 23,57 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 11,43 мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 10,71 хувь нь шилжин суурьшсан; 7,14 хувь нь орон тооны цомхтголд орсон; 4,29 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 3,57 хувь

нь байгууллага татан буугдсан; 3,57 хувь нь цэргээс халагдсан; 2,86 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 2,14 хувь нь хорих газраас суллагдсан; 1,43 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1,43 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 2,14 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 3,16% нь дээд; 8,61% нь тусгай дунд; 50,26% нь мэргэжлийн анхан шатны; 12,30% нь бүрэн дунд; 6,85% нь бүрэн бус дунд боловсролтой; 18,63% нь бага; 0,18% нь боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар**



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



## 1.2 Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 3 сард НДШ-ийн орлого 3.15 тэрбум ₮, төлөвлөгөө 79.56 хувь болж, төлөвлөгөөг бүх сум 1.4-56.8 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 50.3 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 27.98-15.86 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 8.7 тэрбум ₮ зарцуулж, 100.0 хувь олгов. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 257890 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 32.17 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 22.40%; тэтгэмжийн даатгалын сангийн 91.77%; эрүүл мэндийн даатгалын сангийн 108.87%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 185.69%; ажилгүйдлийн даатгалын сангийн 112.21%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 3 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 48376 хүнд олгож, 3.5 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 31.73 хувь 22485 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 2.85 хувь 97.7 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 107930 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.0 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 19.9 хувийг халамжийн тэтгэвэр;

7.1 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 5.1 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.2 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 2.9 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.7 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




## 1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 3 сард 3751 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 13.2 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 3 сард 302 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 37 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2015 оны 3 сарын байдлаар нялхсын эндэгдэл 2 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 1-ээр өссөн байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



2015 оны эхний 3 сард нийт гарсан халдварт өвчнөөр 151 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 33.6 хувь буюу 38 хүнээр өслөө. 2014 оны мөн үеэс, тэмбүү 2 дахин сүрьеэ 10.3, салхин цэцэг 41.6 хувь, тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 17 байгаа бол: Зуунмод 53, Цээл 44, Борнуур 26, Баянцагаан 22, Сүмбэр 17, сэргэлэн 16, ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



#### I.4 Байгаль орчин

Сарын 2-3, 21-нд зарим нутгаар 0,0-0,6 мм, 7-нд нутгийн өмнөд хэсгээр 0,0-1,6 мм, 6, 13, 30-нд ихэнх нутгаар 0,0-2,0 мм, 14-нд бүх нутгаар 0,2-8,4 мм, 18-нд Дэлгэрхаан орчмоор 0,5 мм, 27-нд нийт нутгаар 0,0-12,0 мм цас орлоо. Сарын нийлбэр тунадас 0,4-17,8 мм байна. Хамгийн их нь Зуунмодод 17,8 мм, Мөнгөнморьтод 14,8 мм, Алтанбулагт 10,6 мм 17,8 мм, Мөнгөнморьтод 14,8 мм, Алтанбулагт 10,6 мм цас орж, харин нутгийн баруун болон өмнөд хэсгээр бага хур тунадас

оржээ. Цасны зузаан өртөө харуулуудын талбай дээрх хэмжилтээр сарын эхэнд 0-17 см, хамгийн их нь Жаргалант, Баянчандмань, Борнуур, Залуучууд, Зуунмод, Нөхөрлөлд 9-17 см байснаа дулаарсанаас цас хайлж, 3-р арав хоногт ихэнх нутгаар цасгүй болсон боловч ахин цас орсноос зарим сумдаар 0-6 см байгаа нь өмнөх оноос цас багатай, гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи шуурга болоогүй цаг агаар харьцангуй тогтвортой байлаа.

Салхи ихэнх хугацаанд бүх нутгаар 3-8 м/с, 10, 26, 29-30-нд 9-14 м/с, 16-17, 27-28-нд ихэнх нутгаар 16-18 м/с, түр зуур 20-24 м/с хүрч, цасан болон шороон шуурга шуурлаа.

Сарын 1-р арав хоногийн эхний хагас, сүүлч, /1-4, 7-10-нд/, 2-р арав хоногийн эхэн, дундуур /11, 15-16, 20-21нд/ хүйтэрч, температурын огцом хэлбэлзэл ихтэй байлаа. Хүйтрэх үедээ өдөртөө бүх нутгаар 8-14 градус, шөнөдөө 20-30 градус хүйтэн байв. 5-6, 12-13, 18-19-нд хүйтний эрч суларч, ялангуяа 22-ноос эхлэн 24-25-нд нилээд дулаарч, шөнөдөө ихэнх хугацаанд нийт нутгаар 1-10 градус хүйтэн, өдөртөө нутгийн зүүн хойд хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 17-22 градус дулаан байлаа. Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт агаарын дундаж температур нь нийт нутгаар 0-3 градусаар хүйтэн өдрийн хамгийн их температур нь нийт нутгаар 1-8 градусаар дулаан, шөнийн хамгийн бага температур нь ихэнх нутгаар ойролцоо буюу 0-3 градусаар хүйтэн сум тус бүрээр хур тунадасны нийлбэр ихэнх нутгаар 0,3-16,6 мм-ээр ахиу, Лүн, Заамар, Батсүмбэр орчмоор өмнөх жилээс бага, нутгийн зүүн хэсгээр ахиу үүнээс Зуунмод, Мөнгөнморьт, Алтанбулаг орчмоор бусад сумдаас их цас оржээ. Салхи 6-11 м/с, ихэнх нутгаар 12-14 м/с, түр зуур 16-18 м/с хүрч, цас орох үеэр зарим газраар цасан болон шороон шуурга, явган шуурга ажиглагдав.

2015 оны 3-р сар нь өмнөх оны тухайн сараас хүйтэн байсан нь агаарын дундаж температураас харагдаж байна. 3-р арав хоногт ихэнх нутгаар цасгүй, зарим сумдаар 0-1 см байгаа нь өмнөх оноос цас багатай, гамшигт үзэгдлийн

хэмжээнд хүрсэн хүчтэй салхи шуурга болоогүй цаг агаар харьцангуй тогтвортой байлаа.

Сарын 1-р арав хоногийн эхний хагас, сүүлч, /1-4, 7-10-нд/, 2-р арав хоногийн эхэн, дундуур /11, 15-16, 20-21нд/ хүйтэрч, температурын огцом хэлбэлзэл ихтэй байлаа. Хүйтрэх үедээ өдөртөө бүх нутгаар 8-14 градус, шөнөдөө 20-30 градус хүйтэн байв. 5-6, 12-13, 18-19-нд хүйтний эрч суларч, ялангуяа 22-ноос эхлэн 24-25-нд нилээд дулаарч, шөнөдөө ихэнх хугацаанд нийт нутгаар 1-10 градус хүйтэн, өдөртөө нутгийн зүүн хойд хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 17-22 градус дулаан байлаа.

#### 2015 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

**Төв аймгийн нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур Хэнтийн уулсаар 4 градус хүйтнээс 1 градус дулаан, бусад нутгаар 2-7 градус дулаан байх ба ихэнх нутгаар олон жилийн дунджаас 1.0-1.5 градусаар дулаан байна

**Хүйтрэх үе** Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёдугаар арав хоногийн дунд үе ба сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 12-17 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна.

**Дулаарах үе** Гуравдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр харьцангуй дулаарч шөнөдөө уулархаг нутгаар 4-9 градус хүйтэн, бусад нутгаар 2 градус хүйтнээс 3 градус дулаан, өдөртөө голын хөндийгөөр 21-26 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан байна.

**Бусад хугацаанд** Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 11-16 градус дулаан, зарим нутгаар 15-20 градус дулаан байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн зүүн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, баруун өмнөд хэсгээр олон

жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, сүүлчээр нь зарим газраар, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар, сарын эцсээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Энэ үеүдэд салхи зарим газраар 12-14 м/с, ялангуяа хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурна.

#### *ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ*

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нутгийн зүүн хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутагт олон жилийн дунджаас дулаан байх ба хур тунадас нутгийн 70 гаруй хувьд олон жилийн дунджийн орчим ба түүнээс бага, нутгийн 30 орчим хувьд олон жилийн дунджаас ахиу орох төлөвтэй байна.

4 дүгээр сарын ихэнх хугацаанд нийт нутгаар дулаан, хур тунадас багавтар байх төлөвтэй байгаа нь мал аж ахуйд таатай байх хэдий ч сарын дунд үе болон сүүлчээр нутгийн хойд хагаст хур тунадас нойтон цас орж, нутгийн өмнөд хэсгээр хүчтэй салхилж шороон болон цасан шуурга шуурч малын хариулга, маллагаа хүндэрч, нялх төлд таагүй нөлөөлөхөөр байгааг анхаарах хэрэгтэй.

#### 2015 ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын дундаж температур нь аймгийн зүүн хэсгээр 5-9, бусад хэсгээр 10-15 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард Төв

аймгийн ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.

Зураг I.9

### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2015 оны эхний 3 сард 27 удаа гарсны улмаас 2 хүн амь насаа алдаж, 95 толгой мал хорогдлоо. Энэ онд объектын түймэр 15 удаа, шатсан гэр, орон сууц 26 удаа бүртгэгдлээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2015 оны эхний 3 сард 10.5 сая ₮-ийн хохирол учирлаа.

Аюулт үзэгдэл, осол, 2015 оны эхний 3 сарын байдлаар *			
Үзүүлэлт	2014 III	2015 III	$\frac{2015-III}{2014-III}$ %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдлын тоо	8	27	337.5%
Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний тоо	1	2	200.0%
Шатсан гэр, орон сууцны тоо	2	26	1300.0%
Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтаны тоо	1	95	9500.0%
Объектын түймрийн тоо	2	15	750.0%
Учирсан хохирлын хэмжээ, сая ₮	582.1	10.5	1.8%

Тайлбар: \*- Онцгой байдлын газрын мэдээ

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.88 хувь нь хулгай, 24.19 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.31 хувь нь бусад хэрэг. 16.67 хувь нь замын осол, 4.76 хувь нь танхай дээрэм, 1.19 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Заамар, Батсүмбэр, Борнуур сумдад 10000 хүнд 166-76 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (30)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 31 хэргээр өслөө.

Зуунмод суманд 12 эмэгтэй, 262 эрэгтэй нийт 274 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 9 хүнээр буурлаа.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр.




### I.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 3 сард аймгийн хэмжээнд 269 гэмт хэрэг бүртгэгдэж 230 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 892.7 сая ₮-ийн хохирол учирлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 3 сард кассын орлого 87.0 тэрбум ₮, кассын зарлага 86.9 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.3 тэрбум ₮ байна. ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 3 сарын байдлаар 123.8 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 5.7 тэрбум ₮-өөр өслөө.

2015 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 31.5 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Харилцах дансны үлдэгдэл 3 сарын 31-ны байдлаар 260580 иргэний 8.5 тэрбум ₮ боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.37 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.91 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.


Төв хөгжил, Түмэн мод, Сонин шийдэл кредит, Интерхэлп, Зуун дэлгэрэх банк бус санхүүгийн байгууллагууд 2015 оны эхний 3 сард 1050 зээлдэгч нарт 868.9 сая ₮-ийн зээл олгож, 2.2 тэрбум ₮-ийн зээлийн өр үлдэгдэл байгаагийн 24.2 сая ₮-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл гарлаа.

Арилжааны даатгал эрхлэн явуулдаг байгууллагууд 2015 оны эхний 1-р улиралд 1377 даатгуулагчийг хамруулан 24.0 сая ₮-ийн даатгалын хураамж хуримтлуулж, 14.4 сая ₮-ийн нөхөн төлбөр олгожээ.



### II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 3 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 1.5 тэрбум ₮, зарлага 14.2 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 74.49 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Урсгал орлого, татварын орлого, хувь хүний орлогын албан татвар, орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй татвар, бууны албан татвар, бусад албан татвар, төлбөр, хураамж, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, нохойн албан татвар, хүү торгуулийн орлого, төсөвт газрын өөрийн орлого, түрээсийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.



2014 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 31.45 хувь буюу 201.2 сая ₮-өөр өсч 841.1 сая ₮ болж, авлага 1.0 дахин буюу 87.5 сая ₮-өөр өсч 173.0 сая ₮ боллоо. Орон нутгийн төсвийн орлого 1.5 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 107.18 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 335.4 сая ₮ болж, төлөвлөгөө 149.01 хувь биелж, Батсүмбэр, Дэлгэрхаан, Баянхангай, Баян-Өнжүүл, Борнуур, Аргалант, Лүн, Баянчандмань сумд 35.10-0.30 хувиар тасалдууллаа. Аймагт төвлөрүүлэх

төсвийн орлогын төлөвлөгөө 1218.4 сая ₮ болж 99.47 хувь биелж Өндөрширээт, Алтанбулаг, Заамар, Цээл, Баянхангай, Баян-Өнжүүл, Батсүмбэр, Архуст, Эрдэнэ, Бүрэн, Сүмбэр, Сэргэлэн, Мөнгөнморьт, Аргалант, Жаргалант, Баянцагаан, Лүн сумд төлөвлөгөө 67.71-9.80 хувиар тасалдууллаа.



### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2015 оны 3-р сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 54.72%, өмнөх оны мөн үеэс 7.81%, өмнөх сараас 1.27 хувиар тус тус өсөв.

Зураг II.4

#### Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 3 дугаар сарын 1.27 хувийн өсөлтийн 0,75 нэгж (58.86%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0,32 нэгж (25.39%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,17 нэгж (13.06%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,01 нэгж (1.03%) нь бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ.

Зураг II. 5

#### Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 3 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	1.27	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.75	58.86%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.04	2.89%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.17	13.06%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.01	0.59%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.32	25.39%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.02	-1.52%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЕЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗӨЧИД БУУДАЛ, НИТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	1.03%



### Төл бойжилт

4 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 27.1 хувь 507.6 мянган хээлтэгч мал төллөж, 510.9 мянган төл гарсны 99.3 хувь 507.6 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 16.7 хувь буюу 84.8 мянгаар; бойжиж буй төл 15.4 хувь 78.4 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 11.9; гүүний 5.2; үнээний 11.8; эм хонины 29.4; эм ямааны 29.8 хувь нь тус бүр төллөв.



Гарсан төлийн 0.7 хувь 3392 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 1.1 дахин буюу 1749 төлөөр өслөө. Гарсан унаганы 1.0, тугалын 0.8, хурганы 0.5, ишигний 0.8 хувь нь тус бүр хорогдов. Сүмбэр, Батсүмбэр, Жаргалант, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумд гарсан төлийнхөө 5.3-2.0 хувь буюу 540-23 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 27.9 хувийг (бүгд 948 төл) эзлэв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	2011	2012	2013	2014	2015
<b>Бүгд</b>	<b>278.8</b>	<b>343.4</b>	<b>284.1</b>	<b>429.2</b>	<b>507.6</b>
Ботго	0.0	0.1	0.1	0.1	0.1
Унага	0.4	3.9	1.2	2.6	5.3
Тугал	2.9	7.8	5.2	10.3	13.7
Хурга	160.0	189.8	166.0	243.8	295.0
Ишиг	115.4	141.8	111.6	172.4	193.5

Том малын зүй бус хорогдол


4 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.08 хувь буюу 3200 том мал зүй бусаар хорогдсон нь 2014 оны мөн үеэс 29.9 хувь буюу 1369 толгойгоор буурлаа. Хамгийн их хорогдолтой 5 сум Сүмбэр, Батсүмбэр, Мөнгөнморьт, Баянчандмань, Лүн сумд оны эхний малынхаа 0.56-0.18 хувь буюу 476-92 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 35.6 хувь (бүгд 1142) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо эхний 3 сард төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2011	2012	2013	2014	2015
<b>Бүгд</b>	<b>5409</b>	<b>5268</b>	<b>11351</b>	<b>4569</b>	<b>3200</b>
Тэмээ		1	1	2	2
Адуу	482	520	585	439	287
Үхэр	486	435	764	382	327
Хонь	2216	2002	4550	1873	1342
Ямаа	2225	2310	5451	1873	1242

Оны эхний тэмээний 0.07, адууны 0.09; үхрийн 0.11; хонины 0.06; ямааны 0.09 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 10.5 хувь нь өвчнөөр, 29.7 хувь нь хээлтэгч мал эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, эхний 3 сард



## II.5 Аж үйлдвэр

Өмчийн бүх төрлийн аж үйлдвэрийн газрууд 2015 оны эхний 3 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 1.91 тэрбум₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 31.7 хувь буюу 460.5 сая ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх оны эхний 3 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 37.91, боловсруулах үйлдвэрлэл 58.31, ашигт малтмал олборлолт 3.78 хувийг тус тус эзлэв. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Батсүмбэр, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ, Угтаалцайдам сумд 48.70-2.73 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 82.59) хувийг эзлэв.


Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2013 III	2014 III	2015 III	2014 IV / 2013 IV	%
Нийт дүн	1243.16	1452.07	1912.63	131.7%	
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	20.00	198.71	72.31	36.4%	
Боловсруулах аж үйлдвэр	305.60	543.34	1115.32	205.3%	
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	150.86	710.02	725.01	102.1%	

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ундаа үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод модон эдлэлийн үйлдвэрлэл, цахилгаан дулаан үйлдвэрлэл өмнөх оноос 2.9 дахинаас-2.1 хувь буюу 404.14-9.58 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.



Зураг II.6 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, хувиар



## II.7Тээвэр, холбоо


Холбоо ашиглалтын орлого эхний 3 сард 43823.8 мянган ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 18281.4 мянган ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.48 хувь буюу 14209.9 мянган ₮ өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 24122.1 мян ₮ болж, нийт орлогын 75.06 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 24.93 хувийг албан бичгийн, 12.08 хувийг зорчигчдын, 62.99 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.7


Холбоо ашиглалтын орлого оны эхний

3 сард, сая төгрөгөөр



2015 оны эхний 3 сард авто тээврээр үйлчилгээ хийдэг компани, хоршоо, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд 406 мянган-тонн ачаа, 14738 мян-тонн-км\_ын ачаа эргэлт, 1319 мян-хүнд үйлчлэн 23064 мян-хүн-км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 27.4 мянган-тонноор өсч. Ачаа эргэлт 3779.8 мян-тн-км\_ээр буурлаа. Зорчигч эргэлт 7456.8 мян-хүн-км\_ээр, үйлчлүүлсэн хүний тоо 538 мянган хүнээр нэмэгдлээ.

Тээврийн эхний 3 дугаар сарын байдлаар, сая төгрөг



## Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 3 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 295 гүйцэтгэх хуудсанд нийт 1.34 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 9 гүйцэтгэх хуудсанд ногдох 171.0 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 286 гүйцэтгэх хуудасны 1.17 тэрбум ₮-өөс 90 хуудасны 235.9 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 31.47 хувь, үнийн дүнгээр 20.09 хувь болж 2014 оны мөн

үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 17.81 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 11.65 нэгжээр тус тус өслөө.

### **Шүүх**

Шүүх байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 3 сард 54 эрүүгийн гэмт хэргээр 66 хүн ял шийтгүүлсний 25.93 хувь нь хулгайн; 12.96 хувь нь замын осол; 11.11 хувь нь танхай дээрэм; 7.41 хувь нь хүнд гэмтээх; 1.85 хувь нь хүн амины; 40.79 хувь нь бусад хэрэг эзлэв. Эдгээр таслан шийдвэрлүүлсэн бүх хүний 69.70 хувь нь хорих, 30.30 хувь нь хорихоос бусад ялаар шийтгүүлжээ. Гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж; 23.4 сая ₮-ийн хохирол учирсан нь тогтоогдлоо. Иргэний 87 хэрэг шийдвэрлэв. Давж заалдах шатны шүүхээр эрүүгийн 10, иргэний 4, хяналтын шатны шүүхээр эрүүгийн 1, иргэний 1 хэргийг тус бүр хянан шийдвэрлэжээ. 2014 оны мөн үеэс шүүхээр таслан шийдвэрлүүлсэн эрүүгийн гэмт хэрэг 15-аар өсч, иргэний хэрэг 17-оор буурлаа.

### **Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.**

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 3 сард нийт 2335 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 9.5 сая ₮-ийн орлого орууллаа. Нийт орлогын 52.4 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 28.2 хувийг зээлийн барьцаанаас, 11.1 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 5.6 хувийг худалдааны үйлчилгээнээс, 3.5 хувийг бэлэглэлээс тус бүр оруулжээ. Газар өмчлөх тухай хүсэлт гаргасан иргэдийн 99.75 хувь 31985 иргэнд 6449.76 га газрыг Засаг даргын захирамжаар газар өмчлүүлэхээр шийдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс иргэн 0.93-иар, газрын хэмжээ 707.3 га-гаар нэмэгдлээ.

### **Мал эмнэлэг**

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2015 оны эхний 3 сард 97.4 мянган толгой мал хамрагдсан нь 2014 оны мөн үеэс 2.3 дахин буюу 222.7 мянган толгойгоор буурлаа.

### **Аудит**

Аймгийн аудитын газар 2015 оны эхний 3 сард 165 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 106 нь зөрчилгүй, 23 нь хязгаарлалттай, 1 нь санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтүүдтэй гарлаа. Аудитын үйлчилгээний төлбөр 51.97 сая ₮ оруулахаас, орон нутгийн төсөвт 15.25 сая ₮-ийг орууллаа.

Тайлангийн хугацаанд 3613.7 сая ₮-ийн 102 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 41.0 сая ₮-ийн 2-г барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 1.96, үнийн дүнгээр 1.13 хувьтай гарлаа.